



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 728

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн
тогтоож, балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дархан хотын бохир усны менежментийн МОН-3244/3245" төслийн удирдах нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 143,000,000.00 (нэг зуун дөчин гурван сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий Тоёота Ланд круйзер-200 маркийн, 32-44 УНЧ улсын дугаар, JTMHV05J004169742 арлын дугаартай тээврийн хэрэгслийн ашиглах хугацааг 4 жилээр сунгаж, нийт үнийг 71,500,000.00 (далан нэгэн сая таван зуун мянган) төгрөгөөр шинэчлэн тогтоож "Барилгын хөгжлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Барилгын хөгжлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Ц.Амарсанаа, "Дархан хотын бохир усны менежментийн МОН-3244/3245" төслийн зохицуулагч Д.Мөнхбаатар нарт дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх;

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

123007106
35-r huraldaan.docx